ЗАВХАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Биндэргарав өрхийн эрүүл мэндийн төв-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/112/СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай хот<br>2022 он | Дарга, Тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа<br>Утас: 70463612 Цахим хаяг: batundraa@audit.gov.mn<br>Ахлах аудитор : Б.Дагвасүрэн<br>Утас:99014227 Цахим хаяг:dagvasurenb@audit.gov.mn<br>Аудитор П.Ганцолмон<br>Утас:70157405 Цахим хаяг:uliastaivanaudit@ubaudit.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


1. **Аудитын санал дүгнэлт** ..... 2
2. **Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**
   - 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4
   - 2.2 Аудит хийсэн үр дүнгийн тайлан ..... 5
   - 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 7
   - 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 8
   - 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 10
3. **Аудитын тайлан**
   - 3.1 Ерөнхий зүйл ..... 12
   - 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 12
   - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 12
   - 3.4 Материаллаг байдал ..... 13
   - 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 13
   - 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 14
   - 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 14
   - 3.8 Аудитын гол асуудал ..... 14
   - 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал, Шилэн дансны хуулийн хэрэгжилт, бусад хууль тогтоомж ..... 14
   - 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 15
   - 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 15
4. **Аудитын илрүүлэлт** ..... 15


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1. Төрийн аудитын санал, дүгнэлт

2

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.24 № 1802/244

танай ______________-ны №______________-т

БИНДЭРГАРАВ ӨЭМТ-ИЙН ЭРХЛЭГЧ З.ИЧИНХОРОЛ-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биндэргарав өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Биндэргарав өрхийн эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
## 2.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **23,055,844.16** | **77,353,736.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 39,993.16 | 73,563.82 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 39,993.16 | 73,563.82 |
| **3121** | **Төгрөг** | 39,993.16 | 73,563.82 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 39,993.16 | 73,563.82 |
| **33** | **АВЛАГА** | - | 50,253,600.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 50,253,600.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 23,015,851.00 | 27,026,572.18 |
| **351** | **Түүхий эд материал** | 15,674,574.45 | 18,318,495.63 |
| 35130 | Эм боох материал | 15,674,574.45 | 18,318,495.63 |
| **354** | **Хангамжийн материал** | 7,341,276.55 | 8,708,076.55 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 481,455.00 | 704,455.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,788,110.55 | 6,118,910.55 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 187,000.00 | - |
| 35450 | Барилгын засварын материал | 1,300,000.00 | 1,300,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 584,711.00 | 584,711.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **47,390,395.55** | **48,985,324.17** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 47,390,395.55 | 48,985,324.17 |
| **392** | **Биет хөрөнгө** | 47,390,395.55 | 48,985,324.17 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 9,800,000.00 | 9,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (816,666.66) | (2,449,999.98) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 64,538,998.00 | 79,466,755.56 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (31,844,850.72) | (42,411,553.55) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9,741,519.00 | 9,861,519.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (6,245,515.38) | (7,109,060.81) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 8,010,808.19 | 8,010,808.19 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (5,793,896.88) | (6,183,144.24) |
| 39301 | Програм хангамж | 530,000.00 | 530,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (530,000.00) | (530,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **70,446,239.71** | **126,339,060.17** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | **5,720,400.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 5,720,400.00 |
| **413** | **Өглөг** | - | 5,720,400.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 5,720,400.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 5,720,400.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **70,446,239.71** | **120,618,660.17** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 70,446,239.71 | 120,618,660.17 |
| 511 | Засгийн газраас оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 16,745,599.00 | 16,745,599.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 16,745,599.00 | 16,745,599.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 34,349,056.71 | 84,521,477.17 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 34,349,056.71 | 34,349,056.71 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 50,172,420.46 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 19,351,584.00 | 19,351,584.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **70,446,239.71** | **126,339,060.17** |

## 2.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **253,986,297.75** | **464,691,546.56** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,888,967.75** | **52,507,386.56** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,888,967.75 | 52,507,386.56 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 3,888,967.75 | 52,507,386.56 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 3,888,967.75 | 52,507,386.56 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **250,097,330.00** | **395,384,160.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 233,318,000.00 | 226,317,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 233,318,000.00 | 226,317,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | 16,800,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,550,000.00 | 500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан | 3,550,000.00 | 500,000.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | - | 117,000.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 117,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 13,229,330.00 | 168,449,460.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 13,229,330.00 | 168,449,460.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **226,965,159.83** | **414,519,126.10** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **226,965,159.83** | **414,519,126.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 224,321,457.83 | 393,913,319.10 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 177,474,713.00 | 225,025,711.00 |
| 210101 | Үндсэн цалин | 177,474,713.00 | 225,025,711.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 10,481,998.00 | 27,190,119.64 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,932,504.00 | 18,639,144.64 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 3,600,410.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 450,051.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,549,494.00 | 4,500,514.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,420,615.84 | 1,644,074.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 751,375.84 | 836,498.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 669,240.00 | 807,576.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,816,472.00 | 7,534,780.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,637,480.00 | 1,333,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,681,220.00 | 2,271,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 928,822.00 | 1,449,270.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 100,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, | - | 360,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,568,950.00 | 1,185,170.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 835,540.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 6,724,595.30 | 114,757,026.82 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,628,095.30 | 114,757,026.82 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,096,500.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,913,050.00 | 2,170,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,913,050.00 | 2,170,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,200,300.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,200,300.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,630,869.00 | 1,080,460.70 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 890,700.00 | 622,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,297,100.00 | 127,650.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 49,500.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 230,969.00 | 101,907.70 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 99,000.00 | 146,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 63,600.00 | 60,903.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,658,844.69 | 14,510,346.94 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,893,500.00 | 177,518.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 490,000.00 | 880,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 10,275,344.69 | 13,452,828.94 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,643,702.00 | 20,605,807.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,643,702.00 | 20,605,807.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,643,702.00 | 20,605,807.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **27,021,137.92** | **50,172,420.46** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 17,706,688.97 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 17,706,688.97 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (17,706,688.97) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **9,314,448.95** | **50,172,420.46** |

## 2.3 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **16,745,599.00** | **19,351,584.00** | **34,349,056.71** | **70,446,239.71** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **16,745,599.00** | **19,351,584.00** | **34,349,056.71** | **70,446,239.71** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **16,745,599.00** | **19,351,584.00** | **34,349,056.71** | **70,446,239.71** |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **16,745,599.00** | **19,351,584.00** | **34,349,056.71** | **70,446,239.71** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **16,745,599.00** | **19,351,584.00** | **34,349,056.71** | **70,446,239.71** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 50,172,420.46 | **50,172,420.46** |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **16,745,599.00** | **19,351,584.00** | **84,521,477.17** | **120,618,660.17** |

## 2.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **250,097,330.00** | **361,930,560.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **250,097,330.00** | **361,930,560.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 233,318,000.00 | 226,317,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 233,318,000.00 | 226,317,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | 16,800,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,550,000.00 | 500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,550,000.00 | 500,000.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | - | 117,000.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 117,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 13,229,330.00 | 118,195,860.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 13,229,330.00 | 118,195,860.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **226,401,408.84** | **357,707,189.34** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **226,401,408.84** | **357,707,189.34** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **223,757,706.84** | **337,101,382.34** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 177,461,758.00 | 225,025,711.00 |
| 210101 | Үндсэн цалин | 177,461,758.00 | 225,025,711.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 10,481,998.00 | 27,190,119.64 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,932,504.00 | 18,189,092.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | - | 2,250,257.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | - | 1,800,205.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | - | 450,051.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,549,494.00 | 4,500,514.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 1,420,615.84 | 1,644,074.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 751,375.84 | 836,498.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 669,240.00 | 807,576.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,922,072.00 | 9,091,380.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,673,480.00 | 1,556,800.00 |
| 210402 | Түлш, шатахуун | 2,681,220.00 | 2,271,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 928,822.00 | 1,449,270.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 100,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 360,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,544,100.00 | 2,527,200.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 1,094,450.00 | 827,110.00 |
| **2105** | **Норматив зардал** | 13,467,544.00 | 70,031,119.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 12,371,044.00 | 70,031,119.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,096,500.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,789,050.00 | 1,983,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,789,050.00 | 1,983,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,200,300.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,200,300.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,630,869.00 | 1,077,660.70 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 890,700.00 | 622,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,297,100.00 | 124,850.00 |
| [illegible] | [illegible] | [illegible] | |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 49,500.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 230,969.00 | 101,907.70 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | - | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 99,000.00 | 146,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 63,600.00 | 60,903.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,383,500.00 | 1,057,518.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,893,500.00 | 177,518.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 490,000.00 | 880,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,643,702.00** | **20,605,807.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,643,702.00 | 20,605,807.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,643,702.00 | 20,605,807.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **23,695,921.16** | **4,223,370.66** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **23,699,000.00** | **4,189,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **23,699,000.00** | **4,189,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 23,699,000.00 | 4,189,800.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 11,689,000.00 | 4,189,800.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 12,010,000.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(23,699,000.00)** | **(4,189,800.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (3,078.84) | 33,570.66 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 43,072.00 | 39,993.16 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 39,993.16 | 73,563.82 |

## 2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **230,739,160.00** | **227,115,789.34** | **3,623,370.66** | **98%** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **230,739,160.00** | **227,115,789.34** | **3,623,370.66** | **98%** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **228,647,000.00** | **223,309,982.34** | **5,337,017.66** | **98%** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **182,500,000.00** | **182,423,482.64** | **76,517.36** | **100%** |
| 210101 | Үндсэн цалин | 182,500,000.00 | 182,423,482.64 | 76,517.36 | 100% |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **16,000,000.00** | **15,149,733.00** | **850,267.00** | **95%** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,000,000.00 | 15,149,733.00 | 850,267.00 | 95% |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **1,650,000.00** | **1,644,074.00** | **5,926.00** | **100%** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 840,000.00 | 836,498.00 | 3,502.00 | 100% |
| 210303 | Цэвэр, бохир ус | 810,000.00 | 807,576.00 | 2,424.00 | 100% |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **8,150,000.00** | **8,069,880.00** | **80,120.00** | **99%** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,360,000.00 | 1,351,800.00 | 8,200.00 | 99% |
| 210402 | Түлш, шатахуун | 2,200,000.00 | 2,154,000.00 | 46,000.00 | 98% |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,400,000.00 | 1,399,270.00 | 730.00 | 100% |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 | 180,000.00 | - | 100% |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,350,000.00 | 2,327,200.00 | 22,800.00 | 99% |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 660,000.00 | 657,610.00 | 2,390.00 | 100% |
| **2105** | **Нормативт зардал** | **12,100,000.00** | **12,006,834.00** | **93,166.00** | **99%** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 12,100,000.00 | 12,006,834.00 | 93,166.00 | 99% |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,050,000.00** | **1,983,800.00** | **4,066,200.00** | **33%** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,050,000.00 | - | 4,050,000.00 | 0% |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 1,983,800.00 | 16,200.00 | 99% |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **100,000.00** | **-** | **100,000.00** | **0%** |
| 210702 | Дотоод албан томилолт | 100,000.00 | - | 100,000.00 | 0% |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,017,000.00** | **974,660.70** | **42,339.30** | **96%** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 550,000.00 | 522,000.00 | 28,000.00 | 95% |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 125,000.00 | 124,850.00 | 150.00 | 100% |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 110,000.00 | 101,907.70 | 8,092.30 | 93% |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 | - | 100% |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 150,000.00 | 146,000.00 | 4,000.00 | 97% |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 60,000.00 | 57,903.00 | 2,097.00 | 97% |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,080,000.00** | **1,057,518.00** | **22,482.00** | **98%** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 200,000.00 | 177,518.00 | 22,482.00 | 89% |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 880,000.00 | 880,000.00 | - | 100% |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,092,160.00** | **3,805,807.00** | **(1,713,647.00)** | **182%** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,092,160.00** | **3,805,807.00** | **(1,713,647.00)** | **182%** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,092,160.00 | 3,805,807.00 | (1,713,647.00) | 182% |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **4,189,800.00** | **(4,189,800.00)** | |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **-** | **4,189,800.00** | **(4,189,800.00)** | |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 4,189,800.00 | (4,189,800.00) | |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **230,622,160.00** | **230,622,160.00** | **-** | **100%** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **226,317,700.00** | **226,317,700.00** | **-** | **100%** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 226,317,700.00 | 226,317,700.00 | - | 100% |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **4,304,460.00** | **4,304,460.00** | **-** | **100%** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 4,304,460.00 | 4,304,460.00 | - | 100% |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **-** | **39,993.16** | **(39,993.16)** | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** | **39,993.16** | **(39,993.16)** | |

## 2.6 Аудит хийсэн Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **130,591,400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **130,591,400.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 113,791,400.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 50,764,681.00 |
| 210101 | Үндсэн цалин | 50,764,681.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 3,877,934.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,877,934.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,021,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 205,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 117,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 50,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 100,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 180,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 200,000.00 |
| **2105** | **Норматив зардал** | 58,024,285.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 58,024,285.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 103,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 100,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 3,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 16,800,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,800,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,800,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 500,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 500,000.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Биндэргарав өрхийн Эрүүл мэндийн төв-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага Биндэргарав өрхийн Эрүүл мэндийн төвтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улиастай ван аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ганцолмон, аудитор Д.Гэрэлхүү нар гүйцэтгэж, ахлах аудитор Б.Дагвасүрэн, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Биндэргарав өрхийн Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дугаар сарын 19-ны өдрийн 03/22 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Биндэргарав өрхийн Эрүүл мэндийн төв нь Хүн амд ээлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлснээр аймгийн хэмжээнд тэргүүлэгч байгууллага болох, иргэдэд чанартай, аюулгүй, тэгш, хүртээмжтэй, нотолгоонд үндэслэсэн, эрүүл мэндийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тусламж үйлчилгээг үзүүлэх,оношлогоо, эмчилгээнд орчин үеийн мэдээлэл, технологийг нэвтрүүлж, техник технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэн ажиллах, эмнэлгийн хөгжлийн түвшинг сайжруулах зорилготой Засаг даргын дэргэдэх орон нутгийн өмчийн талаарх бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Биндэргарав өрхийн Эрүүл мэндийн төв нь Дотоод аудитын нэгж байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл

үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Өмнө Биндэргарав өрхийн Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны эхний хагас жилийн нийт орлого 276,816.3 мянган төгрөгийн 1 хувиар буюу 2,768.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,937.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлого 464,691.5 мянган төгрөгийн 1 хувь буюу 4,646.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг түүний 70 хувь буюу 3,252.8 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 40.0 | 73.6 | 33.6 |
| Авлага | - | 50,253.6 | 50,253.6 |
| Бараа | 23,015.8 | 27,026.6 | 4,010.8 |
| Үндсэн хөрөнгө | 47,390.4 | 48,985.2 | 1,594.8 |
| **Нийт хөрөнгө** | **70,446.2** | **126,339.0** | **55,892.8** |
| Өр төлбөр | - | 5,720.4 | 5,720.4 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 70,446.2 | 120,618.6 | 50,172.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө** | **70,446.2** | **126,339.0** | **55,892.8** |

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 73.6 мянган төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл 50,253.6 мянган төгрөгөөр өссөн нь ковидын зардалтай холбоотой татаас санхүүжилтийн авлагаас үүссэн байна.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 4,010.9 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материал, аж ахуйн материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 126,566.8 мянган төгрөг, хандивын хөрөнгөөр 41,649.4 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус олж бэлтгэн, 122,556.1 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,594.8 мянган төгрөгөөр өссөн хандивын хөрөнгөөр машин тоног төхөөрөмж олж бэлтгэсэнтэй холбоотой. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 4,189.8 мянган төгрөг, хандивын хөрөнгөөр 10,857.9 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус олж бэлтгэсэн.

Өглөг данс нь 5,720.4 мянган төгрөг байгаа нь байгууллагад төлөх өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 50,172.4 мянган төгрөг болж өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 230,739.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж батлуулсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 226,317.7 мянган төгрөгийн, төсөв захирагчаас олгосон санхүүжилт 617.0 мянган төгрөг ЭМДС-аас 4,404.4 мянган төгрөгийн, нийт 231,339.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, урсгал үйл ажиллагаанд 227,115.7 мянган төгрөгийг зарцуулсан байна. Цэвэр мөнгөн гүйлгээ 33.6 мянган төгрөг, хөрөнгийн зардал 4,189.8 мянган төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 130,591.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн, 130,591.4 мянган төгрөгийг цалин урамшуулалд 50,764.7 мянган төгрөгийг НДШ-д, хангамж бараа материалын зардалд 3,877.9 мянган төгрөгийг , эмийн зардалд 1,021.5 мянган төгрөгийг , бусад зардалд 58,024.3 мянган төгрөгийг ,нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 16,800.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Нягтлан бодогч нь худалдан авалт хийхдээ и баримтыг бүрэн бүрдүүлээгүй байна.

### 3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын  2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирал бүр мэдээлдэг байна. Тайлант онд 10 сая төгрөгөөс дээш ажил, үйлчилгээ гараагүй байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай нийцсэн байна   гэж дүгнэлээ.

### 3.10 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж хүргүүлснийг биелүүлсэн байна.

### 3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулж авлага, өглөгийн ажил гүйлгээнүүдийг нэхэмжлэл бүртгэх хэлбэрээр зохион байгуулж хэвших.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,534.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,433.4 мянган төгрөгийн зөрчилийг залруулж 3,101.2 мянган төгрөгт 1 зөвлөмж хүргүүллээ.

**4.1 Залруулсан алдаа:** Өрхийн эмнэлэгийн 2 эмчид  олгосон 1,433.4 мянган төгрөгийн тэтгэмж нь "Нөхөрлөлийн тухай хууль"-иар зохицуулагдаж байгаа тул залруууллаа.

**4.2 Төлбөрийн акт хүргүүлээгүй.**

**4.3 Албан шаардлага хүргүүлээгүй.**

**4.4 Зөвлөмж :**

*А*удитаар илэрсэн 3,101.2 мянган төгрөгийн алдаанд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1.Татварын данстай холбоотой асуудал**

- ✓ <u>Илрүүлэлт:</u> Тус байгууллага нь тайлант хугацаанд 91,68.1 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн боловч татварын сайт дахь ибаримтын бүртгэлээр 88,506.8 мянган

төгрөг тайлагнагдаж 3,101.2 мянган төгрөгийн гүйлгээг илүү бүртгэж тайланд тусгасан байна.

- ✓ Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Биндэргарав ӨЭМТ | 3 | 4.6 | 2 | 1.5 | - | - | - | - | 1 | 3.1 |